


2

**МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ
ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР СУДЛАХ НЬ**

Т.Цэгмид, С.Амартүвшин

2009 оны байдлаар дэлхийн хэмжээнд аялал жуулчлалын салбар өмнөх оноосоо 4.3 хувиар унасан хэдий ч 880 сая жуулчин аялал хийж, 852 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авч, 235 сая хүнийг ажлын байраар хангажээ. Үүний 470 тэрбум буюу 53.4 хувь нь хөгжингүй орнуудад ногдож байгаа бол 410 тэрбум буюу 46.6 хувь нь хөгжиж буй орнуудад ногдож байна.

Зураг 1.1



Эх сурвалж: UNWTO

Сүүлийн 15 жилийн хугацаанд аялагчдын тоо 1.7 дахин өсч, түүнээс олж буй орлого нэрлэсэн дүнгээрээ 2.1 дахин нэмэгджээ. 1996-2002 оны хооронд жуулчдын жилийн дундаж өсөлт 2.6 хувь байсан бол 2003-2009 оны хооронд жилд дунджаар 8.8 хувийн өсөлттэй байжээ. Өнгөрсөн жилийн уналтыг оруулахгүй бол жилд дунджаар 11.9 хувийн өсөлттэй байсан. 2009 оны хувьд дэлхийн аялал жуулчлалын салбарт томоохон уналт явагдаж, 2008 оноос 5.8 хувиар буурсан ч дэлхийн аялал жуулчлалын бүс нутгуудын хувьд харилцан адилгүй өөрчлөлттэй байсан юм.

Европ болон Америк тивийн аялал жуулчлалаас олох орлого хамгийн өндөр буюу 5.6 хувиар буурсан бол Ази, Номхон далайн бүс нутагт хамгийн бага буюу 1.7 хувийн уналт ажиглагджээ. Африк тивд ирэх жуулчдын тоо 5.9 хувиар буурсан ч аялал жуулчлалаас олох орлого нь 3.0 хувиар нэмэгдсэн нэмэгдсэн дүнтэй байна. (Зураг 1.2)


Зураг 1.2



Эх сурвалж: UNWTO

Харин Монгол улсын хувьд сүүлийн 10 жилд 3.1 сая жуулчин хүлээн авсан бөгөөд тэдгээрийн 69.4 хувийг нь БНХАУ, ОХУ-ын жуулчид эзэлж байгаа юм байна. 2009 онд Монгол улсад 433 мянган жуулчин ирсэн гэж бүртгэгдсэн нь дэлхийн нийт жуулчны 0.05 хувьтай тэнцэж байна.

Зураг 1.3



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэлүүд, ҮСХ

Монголд 2001 – 2009 оны хооронд ирсэн гадаадын жуулчдын тооны жилийн дундаж өсөлт 15.1 хувь байжээ. 2003 онд Монголд жуулчлагсдын тоо өмнөх оныхоосоо 12.1 хувиар буурсан нь Ази тив тэр дундаа БНХАУ-д тархсан амьсгалын цочмог халтай хам шинж (SARS) өвчинтэй холбоотой байжээ².

² “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн төлөв байдал, салбарыг хөгжүүлэх арга зам, шаардагдах хөрөнгө оруулалт” судалгаа, МУИС – ЭЗС, Б.Даваасүрэн, Р.Энхбат, Б.Эрдэнэчимэг, 2007 он

2004-2007 оны хооронд жилд дунджаар 23.3 хувь өссөн бол 2008 онд 1.7 хувь, 2009 онд 3.0 хувиар тус тус буурчээ.

Сүүлийн 10 жилд Монгол улсын хилийг жуулчлалын зорилгоор БНХАУ-ын 1.4 сая иргэн нэвтэрсэн бол ОХУ-ын 0.7 сая иргэн жуулчлан иржээ. (Хүснэгт 1.1)


Хүснэгт 1.1

Монгол улсад ирсэн жуулчдын тоо										
он	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Нийт жуулчин	137400	165900	228700	201100	300300	338715	385989	451788	446446	433136
БНХАУ	49341	57440	89041	90337	139283	170345	178941	211007	196832	229451
ОХУ	45204	58534	69778	51438	53917	57926	79163	98759	109975	108105
БНСУ	6635	8372	14474	17166	26602	30787	39930	43930	43396	38273
Япон	10283	10247	13262	7717	13092	12952	16707	17238	14939	11401
ХБНГУ	3515	4661	6780	4973	8769	8168	8576	8250	8027	6867
АНУ	5234	5446	6725	5533	9431	10153	11377	12223	12474	11344
ИБУИНВУ	2333	2549	3474	2854	4965	5206	5893	6717	6781	5872
Бусад	14830	18645	25184	21139	44463	43188	45402	53664	54022	21823
Бодит жуулчин	42830	49920	69899	59382	107322	110454	127885	142022	139639	95580

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэлүүд, ҮСХ

Аялал жуулчлалын зорилгоор улсын хил нэвтэрсэн жуулчны бодит тоог гаргахын тулд БНХАУ, ОХУ-ын жуулчны визтэй иргэдийн тоог нийт жуулчдын тооноос хасч “бодит” жуулчдын тоог гаргалаа³. БНХАУ-ын жуулчны визтэй иргэд 2000 онтой харьцуулахад 2009 онд 4.6 дахин өссөн байгаа бол ОХУ-ын иргэд мөн энэ хугацаанд 2.4 дахин өссөн дүнтэй байна. Харин “бодит” жуулчид мөн хугацаанд 2.2 дахин нэмэгджээ.

Зураг 1.4



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэлүүд, ҮСХ

ОХУ, БНХАУ-ын жуулчид өнгөрсөн онд 10.0 хувиар өссөн ч Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо 3.0 хувийн бууралттай гарсан байна. Учир нь хоёр хөршийнхөө жуулчдыг оруулалгүйгээр “бодит” жуулчны өсөлтийг 2009 оны байдлаар тооцвол өмнөх оноосоо 31.6 хувь буурсан нь дэлхийн эдийн засгийн хямралтай үүдэн дэлхий дахинаа аялал жуулчлалын салбар уналтад орсонтой холбоотой байна. 2000-2009 оны хооронд манай улсад ОХУ болон

³ Мөн судалгааны аргачлалыг ашиглав.

БНХАУ-ын жуулчны визтэй иргэдийг оруулалгүйгээр 944933 жуулчин зочилсон байна. Энэ нь албан ёсны статистик мэдээллээрх жуулчдын 22 хувьтай тэнцэнэ.

Үндэсний статистикийн хорооны аргачлалаар аялал жуулчлалын салбараас олж буй орлого 2000 онд 9.5 тэрбум төгрөгийн хэмжээтэй байсан бол 2008 оны байдлаар 67 тэрбум болж, нэрлэсэн дүнгээрээ 7 дахин өсчээ. Өөрөөр хэлбэл, ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэхүйц орлогыг аялал жуулчлалын салбар бий болгосон байна. Харин “Аялал жуулчлалын үндэсний төв”-өөс гаргасан тооцооллоор 2008 онд аялал жуулчлалын орлого 236.9 сая ам.долларт хүрч, ДНБ-ий 4.5 хувьтай тэнцэжээ.

Зураг 1.5



Эх сурвалж: Аялал жуулчлалын статистик мэдээллийн эмхэтгэл 2010

Сүүлийн 10 жилийн хугацаанд аялал жуулчлалын салбараас олж буй орлого 2.2 дахин нэмэгджээ. 2003 онд аялал жуулчлалын орлого 19.6 хувиар буурсан нь Ази даяар тархсан цочмог халтай хам шинж өвчинтэй шууд холбоотой. Харин 2009 онд жуулчдын тоо 3.0 хувиар буурахад тус салбараас олох орлого 10 хувиар буурсан нь манай улс жуулчин гэж бүртгэж буй мэдээлэлээ илүү нарийвчлан харах шаардлагатайг нэг талаараа харуулж байна. Жуулчдын тоо ба түүнээс олох орлого тооцох аргачлал нарийн тогтоогүй байгаа явдал нь судалгаа хийхэд хүндрэл учруулдаг. ҮСХ ба “Аялал жуулчлалын үндэсний төв”-ийн мэдээлэлүүд хоорондоо 4 дахин зөрүүтэй байдаг нь тооцох аргачлалаасаа болдог. ҮСХ-ны аргачлалын дагуу улсын бүртгэлтэй, тайлан тооцоогоо тогтмол ирүүлдэг тур агент, тур операторын үйл ажиллагааны нэмэгдэл өртгөөр аялал жуулчлалын салбарын орлогыг тооцоолдог бол БОЖЯ-ны харьяа

Аялал жуулчлалын үндэсний төв нь Монгол улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын судалгаа болон “ЗТАЖЯ маягт-06”-д үндэслэн тооцдог байна.⁴

Жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбараас олж буй орлого нь газарзүйн байршилтай хэрхэн холбогдох талаар одоо авч үзье. Монгол улсын аялал жуулчлалын тухай хуулийн 3.1.3-т аялал жуулчлалын бүс нутаг гэж Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутаг байна гэж заасан байдаг. Энэ дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үндсэн зургаан бүсийг бий болгох боломжтой гэж зарим судлаачид үзсэн байдаг.⁵ Үүнд:

1. Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий Хөвсгөлийн бүс
2. Түүх соёлын үнэт дурсгалууд бүхий Орхон голын бүс
3. Эх газрын өвөрмөц, онгон байгаль, палеонтологийн олдвор, ховор ан амьтан бүхий Говийн бүс
4. Чингис хааны түүхтэй холбоотой дурсгалт газрууд бүхий Хэнтийн бүс
5. Олон ястны зан заншил, соёлын онцлог бүхий өндөр уулын бүсийн экосистемт Алтайн бүс
6. Улаанбаатар хот орчмын бүс

Зураг 1.6

Аялал жуулчлалын бүсүүд



Эдгээр бүсүүдэд тулгуурлан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол улсад аялал жуулчлал хөгжих суурь болох ёстой гэж үздэг. Мөн аймаг бүр энэ баримтлалд тохируулан аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрүүд боловсруулан ажиллаж байгаа аж. Тэгвэл аялал жуулчлалын салбарын үндэс болсон аялал жуулчлалын


чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн байршилыг авч үзье. 2008 оны байдлаар аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага Монгол улсын хэмжээнд 499 байна.

⁴ Дэд бүтцийн сайдын 2002 оны 55 тоот тушаалын I хавсралтад Аялал жуулчлалын салбарын орлого тооцоолох аргачлалын дагуу Япон улсын нэг жуулчин Монгол улсад дунджаар 8 хонож, хоногт дунджаар 126 ам.доллар зарцуулдаг бол бусад улсын жуулчид дунджаар 12 хоног өнгөрүүлж, хоногт 106 ам.доллар зарцуулах бол хувийн зорилгоор ирсэн жуулчин дунджаар 12 хонож, хоногт 42 ам.доллар зарцуулдаг ба зорчин өнгөрч буй жуулчин дунджаар 5 хоног, хоногт 42 ам.доллар, бусад зорилгоор ирсэн жуулчин дунджаар 18 хонож, хоногт 52 ам.доллар зарцуулдаг гэсэн тооцоог гаргасан байдагт үндэслэн тооцно.

⁵ Монголын аялал жуулчлалын үндэсний төв www.mongolia-tourism.mn

Зураг 1.7

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын байрлал




Эдгээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллагуудын 81 хувь буюу 403 нь Улаанбаатар хотод, 3 хувь буюу 14 нь Төв аймагт, мөн тооны аж ахуй нэгж Хөвсгөл аймагт бүртгэлтэй байна. Бусад аймгуудад 10 хүрэхгүй аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа нь орон нутагт бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа ч үндсэн үйл ажиллагааг удирдах төв нь нийслэлд байрладаг

тогтолцоог харуулж байна. Нөгөө талаас энэ нь гадаадын жуулчдын дийлэнх нь Улаанбаатар хотод түр буудалласны дараа өөрийн зорьсон чиглэлийн аяллаа эхлүүлдэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, тур оператор, тур агентууд нь үйлчлүүлэгчид болон зорилтот зах зээлдээ илүү ойрхон байхын тулд дэд бүтэц сайтай Улаанбаатар хотод байрлах нь оновчтой.

Зураг 1.8

Жуулчны баазуудын нягтрал, аймгуудаар




Улаанбаатар хотод үндсэндээ төвлөрсөн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа явуулах гол тулгуур жуулчны бааз, ангийн отгуудыг аймгуудаар харууллаа. (зураг 1.8)

2009 оны эцсийн байдлаар аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн харьяа 327 жуулчны бааз үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна. Тэдгээрээс

Улаанбаатар хот орчимд 28 жуулчны бааз байрлаж байгаа нь нийт жуулчны баазын 8.5 хувийг бүрдүүлж байгаа бол нийслэлд ойрхон байрлалд нь түшиглэн Төв аймгийн нутаг дэвсгэрт 53 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, Горхи-Тэрэлж, Гачуурт, Хустайн нуруу, Өндөр дов, Цонжин болдог гэх мэт газруудад буюу Улаанбаатар хотоос 150 км радиус дотор 81 жуулчны бааз, амралтын газрууд оршиж байгаа нь Монгол улсын нийт жуулчны баазуудын 25 хувийг эзлэж байна. Хөвсгөл аймагт 50 жуулчны бааз буюу нийт жуулчны баазуудын 15 хувь, Булган аймагт 32 бааз буюу 10 хувь нь оршин байна.

Зураг 1.9
Жуулчны баазуудын орны тоо, аймгуудаар



Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хот орчимд болон Хөвсгөлийн бүс нутагт нийт жуулчны баазуудын тэн хагас нь оршин байна. Харин Говийн бүст 50 жуулчны бааз идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт жуулчны баазуудын 15 хувийг эзлэж байна.

Жуулчны баазуудын тооноос гадна жуулчин хүлээн авах хүчин чадал ихээхэн ач холбогдолтой юм. Улаанбаатар хотод болон төв, суурин газруудад байгаа зочид буудлуудыг оруулаагүйгээр манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, амралтын газрууд нийтдээ 15.6 мянган зочныг нэгэн зэрэг хүлээн авах хүчин чадалтай байдаг.⁶

Монгол орныг зорих жуулчдын 78 хувь нь байгалийн үзэсгэлэнг мэдрэхээр ирдэг бол 21 хувь нь Чингис хааны нутаг, Монгол соёлтой танилцахыг зорилгоо болгодог байна.⁷

Нөгөөтэйгүүр Монголын эртний нийслэлийн туурь оршин буй Өвөрхангай болон Монгол говийн илэрхийлэл Өмнөговь аймагт жуулчдын 1/3 нь заавал очдог.⁸ Өвөрхангай аймагт ирсэн жуулчдын хувьд эртний нийслэл Хархорин, Эрдэнэзууд зочлон эртний гүрний түүхээр аялдаг бол Өмнөговь аймагт зочлогчдын хувьд Ёлын ам, Хонгорын гол, Баянзаг гэх мэт байгалийн үзэсгэлэнг сонирхдог байна. Хөвсгөл, орхон гол ба говийн бүсүүдэд жуулчны баазуудын багтаамж хамгийн их байгаа бөгөөд Хөвсгөлд 2006 ортой, Архангайд 1136, Булганд 1408, Өвөрхангайд 940 ортой, Өмнөговьд 1603 ортой жуулчны баазууд үйл ажиллагаа явуулж байгаа нь улсын дүнгийн 45 хувийг эзлэж байна. Харин Улаанбаатар орчмын бүст жуулчны баазуудын нийт орны 30 орчим хувь нь байдаг.


⁶ “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын лавлах”, АЖҮТ, 2010 он

⁷ “2005 онд Монгол улсад олон улсын аялал жуулчлалын талаар хийсэн судалгаа”, USAID

⁸ Мөн судалгаанаас авав

Зураг 1.9

Жуулчдын хамгийн их очсон нутгууд



Жуулчдын хамгийн их очдог нутаг нь Өвөрхангай болон Өмнөговь аймгууд байгаа бол нийт жуулчдын 20 хувь нь Хөвсгөл болон Архангай аймгуудад зочлодог байна. Архангай аймагт зочлогчдын хувьд Тэрхийн цагаан нуур орчмын байгалийн үзэсгэлэнг сонирхдог байна. Харин Улаанбаатар хотын орчимд буюу Тэрэлжийн бүсэд

Монголд зочилсон жуулчдын 20 орчим хувь очдог. Баян-Өлгий аймгийн хувьд Монголын аялал жуулчлалын чухал бүсүүдийн нэг бөгөөд ангийн отгууд байрладаг, адал явдалт аялал хийхэд тохиромжтой бүс гэж үздэг байна. Хэнтий аймагт Чингис хаан, Монголын эзэнт гүрний түүхийг сонирхогч жуулчид илүү их зочлох хандлагатай байдаг бол Дорнод аймгийн хувьд дорнод Монголын тал хээрийн экосистемийг сонирхсон жуулчдын зочлох газар болдог байна. Бусад аймгуудын хувьд гадаадын жуулчдыг хүлээн авах нь бага, жуулчдын сонирхлыг татах маркетингийн үйл ажиллагаа харьцангуй сул явуулдаг нь харагдаж байна.

Манай улсын аялал жуулчлалын салбар 2010 онд 8.9 хувийн өсөлттэй байх ба 2020 он хүртэл жилд дунджаар 8.1 хувь өсч, өнөөгийн түвшнээс хоёр дахин нэмэгдэнэ. Үүнтэй уялдан аялал жуулчлалын салбарт ажиллагчдын тоо 2010 онд 7.1 хувиар өсч, ойрын 10 жилд дунджаар 0.8 хувийн өсөлттэй байна гэж зарим судлаачид үзэж байна.⁹ Ийнхүү таамаглаж байгаа шалтгаанаа тайлбарлахдаа манай улсын хоёр хөрш болох БНХАУ, ОХУ-ын аялал жуулчлал ойрын ирээдүйд эрчимтэй өснө гэж таамаглаж байгаатай холбожээ. Хөршүүдэд аялах жуулчдын тоо нэмэгдэх нь манай улсад дамжин аялах жуулчдын тоог нэмэгдүүлэх сайн талтай.

Монгол улсад жуулчны визээр нэвтрэгсдийн 2/3 нь ОХУ ба БНХАУ-ын иргэд байдаг бол БНСУ, Япон улсын жуулчид дараагийн том сегмент болдог.

⁹ “Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлж буй нөлөө 2010 Монгол улс”, Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл

Зураг 1.10
Монголын аялал жуулчлалын сонирхлын бүс




Манай улс нь дэлхийн аялал жуулчлалын бүсчиллийн дагуу зүүн хойд Азид багтдаг бөгөөд энэ бүсэд БНХАУ, Монгол, БНСУ, Япон, ОХУ-ын зүүн хэсгийн муж, автономит улсууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Манай оронд зочлогчдын 78 хувийг хөршүүд, 12 хувийг БНСУ, Япон, Тайваний жуулчид эзэлнэ. Өөрөөр хэлбэл,

Монголд жуулчлагчдын 90 хувийг зүүн хойд Азийн бүст багтах орнуудын иргэд бүрдүүлж байна.

Аялал жуулчлалын салбарын кластерыг өргөжүүлэх ба бэхжүүлэх нь Монгол улс нь Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг өрсөлдөх чадварын индексээрээ 2009 онд 133 орноос 117-р байранд эрэмбэлэгдэж байгаа нь өмнөх оноосоо 17 байраар ухарсан дүнг илэрхийлж байна. Өрсөлдөх чадварын индекс нь эдийн засаг, нийгмийн үндсэн 12 багц үзүүлэлтэд тулгуурлан тооцогддог бөгөөд 2000 оноос эхлэн тооцсон байдаг. Монгол улсын өрсөлдөх чадварыг 2005 оноос эхлэн гаргах болжээ.

Зураг 2.1




Эх сурвалж: Дэлхийн өрсөлдөх чадварын илтгэлүүд, ДЭЗФ

Хэдийгээр манай улсын өрсөлдөх чадварын индекс өсч буй ч бусад улсуудын өсөлттэй харьцуулахад муу байгаа нь харагдаж байна. 2009 оны байдлаар өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсэг ямар байгаа талаар дараах зурагт харуулав.

Зураг 2.2

Өрсөлдөх чадварын индексийн бүрэлдэхүүн хэсгүүд




Эх сурвалж: Дэлхийн өрсөлдөх чадварын илтгэл: 2009-2010, ДЭЗФ

Долоо хүртэлх оноотой коэффициентээр тооцдог уг үзүүлэлтээр Монгол улс нь харъяалагдаж буй бүлгийнхээ түвшингээс зөвхөн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтээрээ л давж гарч байгаа бол бусад үзүүлэлтээрээ бага буюу ижил түвшинд байна. Хүчин зүйлст тулгуурлан хөгжиж байгаа улс орнууд гэдэг нь өрсөлдөх чадварын үзүүлэлтээрээ хамгийн муу байгаа орнуудыг багтаадаг бүлэг юм. Гэтэл Дэлхийн банкнаас жил бүр тооцон гаргадаг Бизнес эрхлэх орчны индексийн 2010 оны үзүүлэлтээр 183 улсаас 60-р байранд орсон байна.

Зураг 2.3


Монгол улсад бизнес эрхлэхэд хамгийн их саад болдог хүчин зүйлүүд



Эх сурвалж: Doing Business 2010, WB

Уг индексийн судалгаагаар Монголд бизнес эрхлэхэд саад болж буй хамгийн их асуудалтай хүчин зүйлүүдийг нэрлүүлэхэд засаглалын хүнд суртал гэж хариулсан байна. 2008 онд Харвардын их сургуулийн профессор М.Портер Монголын улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг судлан кластер байгуулан өрсөлдөх боломжтой салбаруудыг дурьдсан байдаг.

Зураг 2.4




Эх сурвалж: *Competitiveness: Creating a Mongolian Economic Strategy*, ISC, HBS

Эндээс үзвэл уул уурхай, арьс ширэн бүтээгдэхүүн, оёмол сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон аялал жуулчлалын салбарын кластерыг хөгжүүлэх боломжтой гэсэн санаа дэвшүүлсэн байдаг.

Үүнээс гадна Дэлхийн эдийн засгийн форумаас 2007 оноос эхлэн Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексийг тооцон гаргах болсон бөгөөд 2007 онд голлох 124, 2008 онд 130, 2009 онд 133 улсаар тооцон гаргаад байна. Уг индекс нь гурван үндсэн бүрэлдэхүүнтэй 14 үндсэн хэмжүүрээр тооцон гаргадаг бөгөөд хамгийн дээд үзүүлэлт нь 7 коэффициентийг хангадаг. Манай улсын хувьд 3.5 гэсэн индекстэй байна. Харин аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр манай улс уруудах хандлагатай 133 орноос 105-рт эрэмбэлэгджээ. Эдийн засгийн салбаруудын сул байгаа явдлыг арилгах арга зам нь боломжит, чадавхит үйлдвэрлэлийн салбарууддаа түшиглэсэн кластер байгуулах явдал гэх хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй түгэж байна. Иймээс ч өрсөлдөх чадварын чиглэлээр судалгаа хийдэг олон алдартай эдийн засагчид Монголд айлчлаад байна. (Зураг 2.5)

Зураг 2.5


Монгол улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар



Эх сурвалж: Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын илтгэл: 2009, ДЭЗФ

Профессор М.Портер Монгол улсад кластер хөгжүүлэх боломжийн талаар судалсан бол түүний дараа Дэлхийн банкны судалгааны багууд Монгол улсад уул уурхай, мах, ноолуур, аялал жуулчлал, мэдээллийн технологийн гэсэн таван кластерыг байгуулах боломж байгааг тодорхойлон гаргасан байдаг.¹⁰ Эдгээр судалгаануудад аялал жуулчлалын кластерыг хоёр хэлбэрээр тоймлон харуулсан байдаг. Харин энэхүү судалгааны хүрээнд аялал жуулчлалын кластерыг илүү нарийвчлан харуулж, тулгарч буй бэрхшээлийг тодруулан гаргахыг оролдлоо. Эдийн засгийн аливаа салбарын кластерт голлох буюу цөм бизнесүүд, түүнийг дэмжих, хамтран ажиллах бизнесүүд болон кластер амжилттай оршин тогтнох хөрс болсон дэд бүтцийн салбарыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Аялал жуулчлалын кластерын цөм бизнесийн хэсэгт аялал жуулчлалын 499 компани, 327 жуулчны бааз, 292 зочид буудал (үүнээс 68 нь 1-5 одны зэрэглэлтэй) багтана.

Зураг 2.6
Аялал жуулчлалын кластер диаграмм




Аялал жуулчлалд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг 123 ресторан, 50 гаруй музей, 49 бэлэг дурсгал, 13 аяны хэрэгслийн дэлгүүрүүд болон санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд дэмжих үйл ажиллагаа явуулна. Тус салбарын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх 47 их, сургууль, хөтөч, тайлбарлагч бэлтгэх 10

¹⁰ “Mongolia: Building a National Value Proposition for Competitiveness”, Scoping Report, Jorge Ramirez Vallejo, HBS, 2009

сургалтын төв, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 17 төрийн бус байгууллагууд болон судалгааны байгууллагууд биет бус дэд бүтцийг бүрдүүлэх бол зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц нь биет дэд бүтцийг бий болгох юм. Тэгвэл биет болон биет бус дэд бүтцүүд нь кластерын суурь болж өгөх бөгөөд дараах байдалтайгаар дүрслэн үзүүлээ.

Зураг 2.7

Монголын аялал жуулчлалын кластерын бүдүүвч



Амжилттай хөгжих клатер байгуулах боломжтой эсэхийг судлахдаа хэд хэдэн алхамуудыг шалгадаг. Дэлхийн банкнаас кластерын шинжилгээ хийх хэд хэдэн аргуудыг зөвлөмж болгосон байдаг. Энэ аргуудаас SWOT шинжилгээг хийж, Монголын аялал жуулчлалын өртгийн сүлжээний энгийн загварыг босгон харууллаа.

Дүгнэлт.

Судалгаанаас үзэхэд Монгол улсад аялал жуулчлалын салбар цааши д хөгжих боломжтой байгаа юм. Жуулчлалын салбар нь манай улсын хувьд улирлын шинж чанартай байдаг учир энэ салбарыг тотвортой хөгжүүлэхийн тулд улирлын онцлогт тохирсон чиглэлүүдийг шинээр хөгжүүлэх, ялангуяа хил орчмын аялал жуулчлалыг чухалчлан авч үзэх шаардлага тавигдаж байна. Аялал жуулчлалын салбарыг бүхэлд нь цогц хэлбэрээр хөгжүүлэх замаар

эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж болно. Бид судалгаан дээрээ үндэслээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аялал жуулчлалын салбарын бүсчилсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, биет бус болон биет дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарах;
2. Судалгаанаас харахад Өвөрхангай, Хөвсгөл аймгуудад жуулчлалыг маш ихээр татдаг болох нь харагдаж байна. Иймд эдгээр бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг төрийг бодлогын хүрээнд авч үзэх;
3. Аялал жуулчлалын салбарын цөм болон дэмжих бизнесийн төрлийг олшруулж, тэдгээрийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэх цогц бодлого хэрэгжүүлэх;
4. Шинээр бий болж чөлөөт бүсийн боломжид тулгуурлан хил орчмын буюу хоёр хөшийн аялал жуулчлалыг зуучлан хөгжүүлэх бодлого баеримтлах;
5. Улирлын шинж ялангуяа (намар, өвлийн) чанартай аялал жуулчлалыг идэвхжүүлэх замаар энэ салбарын тогтвортой хөгжлийг хангах;

Ном зүй:

- Монгол улсын хууль (2000) “Аялал жуулчлалын тухай хууль”
- Монгол улсын их хурлын тогтоол (2008) “Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”
- Монгол улсын Засгийн газрын тогтоол (2010) “Аялал жуулчлал үндэсний хөтөлбөр”
- Б.Даваасүрэн, Р.Энхбат, Б.Эрдэнэчимэг (2007) “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн төлөв байдал, салбарыг хөгжүүлэх арга зам, шаардагдах хөрөнгө оруулалтын судалгаа”, МУИС – ЭЗС
- Cluster Navigators Ltd (2001) “Cluster Building: A Toolkit A Manual for starting and developing local clusters in New Zealand”, 2001
- Michael Porter, Christian Ketels (2008) “Analysis of the Moroccan Tourism Cluster” Harvard Business School
- Jeremy Fischer, Imran Khan (2009) “Jordan Tourism Cluster” Harvard Business School
- UNWTO “World Tourism barometer 2010” Jan, Apr.
- WTTC “Progress and Priorities 2008/09” Mongolia, Russia, China and Global.
- World Economic Forum (2001-2009) “The Global Competitiveness Report”,
- World Economic Forum (2007, 2008 and 2009) “The Travel and Tourism Competitiveness Report”
- Michael E. Porter (2008) “Competitiveness: Creating a Mongolian Economic Strategy” Harvard Business School

- Jorge Ramirez Vallejo (2009) “Mongolia: Building a National Value Proposition for Competitiveness” Scoping Report Harvard Business School
- Saha Dhevan Meyanathan (2010) “Crisis is a Window of Opportunity: Articulating Pragmatic Innovation Agenda in Five Industry Clusters in Mongolia” World Bank
- Michael E. Porter (1990) “The Competitive Advantage of Nations” Published by Free Press
- Үндэсний статистикийн хороо (2004) “Монгол улс зах зээлд: Статистикийн эмхэтгэл 1989-2002”
- Үндэсний статистикийн хороо (2005, 2006, 2007,2008) “Статистикийн эмхэтгэл”
- Аялал жуулчлалын үндэсний төв (2010) “Аялал жуулчлалын статистик мэдээллийн эмхэтгэл” Migma Print
- Аялал жуулчлалын үндэсний төв (2010) “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын лавлах” Migma Print
- www.unwto.org
- www.wttc.org
- www.worldbank.org
- www.mongolia-tourism.mn